



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 8 сарын 27 өдөр

Дугаар 629

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3, 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн хөрөнгөөр бий болсон 5 нэрийн, нийт 76,000,000.00 (далан зургаан сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал О.Отгонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

31-8-нуралдаан 85

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны..... дугаар сарын.....ны өдрийн  
649 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН  
БҮСИЙН ЗАХИРГААНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ /ширхэг/	Балансад бүртгэх үнэ /төгрөг/
1	Малын өвөлжөө, хаваржаа хашаа	2022.10.10	1	26,500,000.00
2	Малын өвөлжөө, хаваржааны саравч	2022.10.10	1	19,500,000.00
3	Зөөврийн төмөр хашаа	2022.10.10	1	16,000,000.00
4	Малд эмчилгээ үйлчилгээ хийх төрөөхөмж	2022.10.10	1	9,000,000.00
5	Малд эмчилгээ үйлчилгээ хийх Багаж төхөөрөмж иж бүрдэл	2022.10.10	1	5,000,000.00
Нийт дүн			5	76,000,000.00 (далан зургаан сая төгрөг)